



**СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ**

2026 оны 01 сарын 30 өдөр

Дугаар 77.

Сүхбаатар сум

“Чадварлаг эмч, чадварлаг сувилагч, чадварлаг
эмнэлгийн мэргэжилтэн” хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.6, 35 дугаар зүйлийн 35.1.8, 35.1.18 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.3 дахь заалт, аймгийн Засаг даргын 2025-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.3.2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Чадварлаг эмч, чадварлаг сувилагч, чадварлаг эмнэлгийн мэргэжилтэн” аймгийн хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.

2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай зардлыг төсөвлөж, батлуулах, хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг нэгдсэн удирдлагаар ханган, үр дүнг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулж ажиллахыг аймгийн Засаг дарга (Н.Лхагвадорж)-д үүрэг болгосугай.

3. Хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэхэд төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудын идэвх, санаачилга, оролцоог ханган ажиллахыг бүх шатны Засаг дарга нарт даалгасугай.


ДАРГА

Г.БАТ-ОРХОН



4326010029

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2026 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн
77 дугаар тогтоолын хавсралт



**“ЧАДВАРЛАГ ЭМЧ, ЧАДВАРЛАГ СУВИЛАГЧ, ЧАДВАРЛАГ ЭМНЭЛГИЙН
МЭРГЭЖИЛТЭН БЭЛТГЭХ ХӨТӨЛБӨР”**

Нэг.Ерөнхий мэдээлэл:

Нэг. Нийтлэг үндэслэл:

Монгол Улсын Их Хурлаар “Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд зааснаар Монгол Улсын урт болон дунд хугацааны бодлогын баримт бичгийг үндэслэн аймаг, нийслэлийн дунд болон богино хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг боловсруулна. Аймгийн хувьд дунд хугацааны хөгжлийн төлөвлөлтийн баримт бичиг нь аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл байх бөгөөд үүнийг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусган хэрэгжүүлэхээр байгаа билээ.

Эрүүл мэндийн тухай хуулийн 11.1.2-д зааснаар “Аймгийн Засаг дарга харьяалах нутаг дэвсгэртээ хүн амын эрүүл мэндийг хамгаалах, дэмжих, ойрын ба хэтийн төлөвийг тодорхойлсон хөтөлбөр, төсөл боловсруулж, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулж, гарсан шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулна” гэж тусгасан.

Монгол Улсын “Алсын хараа 2050” урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний зорилт 2.2 дахь хэсэг, 4 дахь заалтад Эрүүл мэндийн хүний нөөцийн хангалт, ур чадвар, нийгмийн хамгааллыг сайжруулсан байна.

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.1(аймгийн дунд хугацааны хөгжлийн үндсэн чиглэл, бодлого, төлөвлөлт;), 20.1.5 (орон нутгийн хүний нөөцийн бодлогын төлөвлөлт, хөтөлбөр;), 21 дүгээр зүйлийн 21.1.1, 21.1.6 (аймгийн хүний нөөцийн бодлогын төлөвлөлт, хөтөлбөр;), 22 дугаар зүйлийн 22.1.6 дахь заалт (аймгийн хүний нөөцийн хөтөлбөрийн хэрэгжилт, ажиллах нөхцөл;);

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.3.4 дэх хэсэг (Монгол Улсад оношлогдож, эмчлэгдэх боломжгүй өвчин, эмгэгийг оношлох, эмчлэх зорилгоор шинэ, дэвшилтэт технологи, арга, аргачлал нэвтрүүлэх, хүний нөөцийг бэлтгэх, сургах, гадаадын ур чадвар бүхий мэргэжлийн багийг эх орондоо урьж, туршлага солилцуулах арга хэмжээг хэрэгжүүлнэ.) гэж тус тус заасан байдаг.

Олон улсын хөдөлмөрийн байгууллагаас 2023 оны “үнэ цэн бүхий ажил, мэргэжлийн тайлан”-д эрүүл мэндийн мэргэжил нь найман чухал ажлын нэг болохыг тодорхойлсон байдаг. Гэсэн хэдий ч эрүүл мэндийн ажилтнуудад биет болон биологийн аюул, нийгэм-сэтгэл зүйн эрсдэл тулгарахаас гадна цалин багатай,

уртасгасан болон тогтмол бус цагаар ажиллах зэрэг нь тэрхүү үнэ цэнийг буурулж байгааг дурджээ.

Мөн халдварт болон халдварт бус өвчний тархалт, байгалийн гамшиг, уур амьсгалын өөрчлөлт, хүн амын насжилт, анагаах ухааны технологийн хурдацтай хөгжлийг даган өсөн нэмэгдэж байгаа эрүүл мэндийн хэрэгцээг хангахад эрүүл мэндийн ажилтнуудын мэргэжил боловсрол, мэргэшлийн ур чадвар, хүчин чармайлт, үүрэг хариуцлага нэмэгдсээр байна. үүнтэй уялдуулан эрүүл мэндийн ажилтны ур чадварыг тасралтгүй хөгжүүлэх, тэдний ажлын байрыг баталгаатай болгож, тогтвор суурьшилтай ажиллуулах, урамшуулах, дэмжих нь нэн чухал асуудал болж байна.

Түүнчлэн Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн хөгжлийг дэмжих арга хэмжээний (2025-2028) төлөвлөгөөнд хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, хүний нөөцийн үр дүнтэй бодлогыг хэрэгжүүлэн эрүүл мэндийн ажиллах хүчний хүрэлцээ, хүртээмж, хүлээн зөвшөөрөгдөх байдал болон чанарыг сайжруулснаар бүх нийтийн эрүүл мэндийн хамралт, тогтвортой хөгжлийн зорилтод хүрэх болохыг тодорхойлсон.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн “Аймгийн Засаг даргын 2025-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” 16 дугаар тогтоолын 2.3.2.3 “Чадварлаг эмч, чадварлаг сувилагч, чадварлаг эмнэлгийн мэргэжилтэн” хөтөлбөр хэрэгжүүлж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэхээр баталсан бөгөөд Монгол Улсын Эрүүл мэндийн сайдын 2025 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн А/379 тушаалаар “Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн хөгжлийг дэмжих арга хэмжээн” 2025-2028 оны төлөвлөгөө батлагдсан тул уг хөтөлбөрийг орон нутгийн онцлогт тохируулан боловсруулах шаардлага үүсэж байна.

Хоёр.Хөтөлбөрийн зорилго, зорилт, хамрах хүрээ

2.1. Хөтөлбөрийн зорилго:

Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийг бэлтгэх, давтан сургах, мэргэшүүлэх, хөгжүүлэх тогтолцоог салбарын хэрэгцээтэй уялдуулан, эмнэлгийн мэргэжилтний ёс зүй төлөвшил, нийгмийн баталгааг сайжруулж, үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэх замаар хүн амд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ.

2.2.Хөтөлбөрийн зорилт:

2.2.1. Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийг бэлтгэх, давтан сургах, мэргэшүүлэх, ажилтанд мэргэжлийн мэдлэг, ур чадвараа тасралтгүй хөгжүүлэх боломжийг бүрдүүлж салбарын хүний нөөцийн хэрэгцээтэй уялдуулах;

2.2.2. Эрүүл мэндийн ажилтны нийгмийн баталгааг хангах дэмжлэгт орчныг сайжруулж, санхүүгийн болон санхүүгийн бус урамшууллын уян хатан тогтолцоог бий болгон тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг бүрдүүлэх;

2.2.3. Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, хандлагыг сайжруулах

**Гурав. Хөтөлбөрийн зорилтуудыг хэрэгжүүлэх үндсэн үйл ажиллагаа,
арга хэмжээ**



3.1. Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийг бэлтгэх, давтан сургах, мэргэшүүлэх, ажилтанд мэргэжлийн мэдлэг, ур чадвараа тасралтгүй хөгжүүлэх боломжийг бүрдүүлж салбарын хүний нөөцийн хэрэгцээтэй уялдуулах хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

3.1.1. Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн ирэх 5 жилийн хэрэгцээг судлаж, төлөвлөлт хийх;

3.1.2. Эрүүл мэндийн салбарын эрэлт, хэрэгцээнд нийцсэн мэдлэг, чадвар, хандлага бүхий эрүүл мэндийн ажилтныг бэлтгэх;

3.1.3. Шинэ сувилагч, эх баригчийг ажлын байранд мэргэшүүлэх;

3.1.4. Сувилахуйн чиглэлээр суралцаж буй оюутныг суралцангаа туслах сувилагчаар ажиллах нөхцлийг бүрдүүлэх;

3.1.5. Эрүүл мэндийн байгууллагад ажиллах олон нийтийн эрүүл мэндийн ажилтан бэлтгэх

3.1.6. Нэн шаардлагатай мэргэшлээр эрүүл мэндийн ажилтан бэлтгэх;

3.1.7. Орон нутгийн захиалгаар элсэх төрөлжсөн мэргэшлийн сургалтын элсэлтийн тоог тэргүүлэх өвчлөлд тулгуурлан төрөлжүүлэх, нэмэгдүүлэх;

3.1.8. Сувилагч, туслах сувилагчдыг бэлтгэх арга хэмжээг хэрэгжүүлэх;

3.1.9. Орон нутагт Ерөнхий мэргэшлийн сургалт эрхлэх байгууллагын тоог нэмэгдүүлж, сургалт эрхлэх чадавхийг бэхжүүлэх;

3.1.10. Аймгийн нэгдсэн эмнэлгийг сургалт эрхлэх байгууллага болгож, сургалтыг хэрэгжүүлэх;

3.1.11. Ахлах ангийн сурагчдад анагаах ухаан, эрүүл мэндийн чиглэлээр ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сургалт, үйл ажиллагаа зохин байгуулах;

3.2. Эрүүл мэндийн ажилтны нийгмийн баталгааг хангах дэмжлэгт орчныг сайжруулж, санхүүгийн болон санхүүгийн бус урамшууллын уян хатан тогтолцоог бий болгон тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг бүрдүүлэх хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

3.2.1. Эрүүл мэндийн байгууллагын удирдлага, хүний нөөцийн ажилтнуудын зөвлөгөөнийг жил бүр зохион байгуулах

3.2.2. Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн удирдлагыг бэхжүүлэхэд орон нутгийн оролцоог нэмэгдүүлэх;

3.2.3. Төгсөлтийн дараах сургалт эрхлэгч байгууллагын үйл ажиллагаанд хяналт, үнэлгээ хийх, шалгуур үзүүлэлтийг үнэлж, тогтмол сайжруулах;

3.2.4. Ажлын байран дахь төгсөлтийн дараах сургалтын хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх;

3.2.5. Эмч, сувилагч мэргэжлийн ур чадвараа тасралтгүй дээшлүүлэх нөхцлийг сайжруулах (цахим сургалт, симуляцийн сургалт г.м)

3.2.6. Эмч, эмнэлгийн мэргэжилтнийг гадаад улсад урт, богино хугацааны сургалтад багаар нь хамруулах;

3.2.7. Эмч, эмнэлгийн мэргэжилтнийг гадаад улс орнуудад төгсөлтийн дараах резидентийн сургалтад хамруулах;

3.2.8. Эрүүл мэндийн байгууллага хооронд эмч мэргэжилтний солилцооны хөтөлбөр хэрэгжүүлэх;

3.2.9. Эрүүл мэндийн байгууллагуудад лавлагаа шатлалын болон төрөлжсөн мэргэшлийн эмнэлгүүдээс эмч мэргэжилтнийг урьж ажиллуулах, ажлын байрны сургалт явуулах;

3.2.10. Хамтын ажиллагаатай улс орнуудын эрүүл мэндийн байгууллага, эмч мэргэжилтний хамтарсан эрдэм шинжилгээний хурал, уулзалт зөвлөгөөн зохион байгуулах;

3.2.11. Сумдын Засаг дарга, Эрүүл мэндийн төвийн даргатай байгуулсан хамтран ажиллах гэрээг холбогдох талуудтай хамтран үнэлэх;

3.2.12. Эрүүл мэндийн байгууллага бүр эрүүл мэндийн ажилтныг шаардлага хангасан нэгдсэн загвар бүхий ажлын хувцас, ажлын хэрэгслээр бүрэн хангаж, тогтмол хугацаанд хангах;

3.2.13. Эрүүл мэндийг дэмжигч эрүүл мэндийн байгууллага хөдөлгөөн өрнүүлэх;

3.2.14. Эрүүл мэндийн ажилтны орон сууцны нөхцлийг сайжруулах арга хэмжээг холбогдох орон нутгийн засаг захиргааны байгууллагатай хамтран хэрэгжүүлэх;

3.2.15. Эрүүл мэндийн ажилтнуудыг орон сууцны ипотекийн зээлд хамруулах чиглэлээр банкуудтай хамтран ажиллах;

3.2.16. Эрүүл мэндийн ажилтны нийгмийн хамгааллын чиглэлээр нэвтрүүлсэн шилдэг санаачилга, үйл ажиллагааг шалгаруулж сурталчлах, түгээн дэлгэрүүлэх;

3.2.17. Эрүүл мэндийн ажилтныг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах, хяналтад авах, эмчлэн эрүүлжүүлэх ажлыг зохион байгуулах;

3.2.18. Эрүүл мэндийн ажилтны нэр хүнд, мэргэжлийн онцлог, үйл ажиллагааг сурталчлах чиглэлээр хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран ажиллах;


3.3. Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, хандлагыг сайжруулах хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

3.3.1. Эмч эмнэлгийн мэргэжилтнүүдэд “Зөөлөн ур чадвар”-ын чиглэлээр тасралтгүй мэргэжлийн боловсрол олгох сургалтыг зохион байгуулах, хамруулах;

3.3.2. Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй хариуцлага, харилцаа хандлагын асуудлаар хэлэлцүүлэг зохион байгуулах

3.3.3. Эрүүл мэндийн ажилтан болон олон нийтэд чиглэсэн мэргэжлийн ёс зүй болон зан үйл харилцаа хандлагыг өөрчлөх соён гэгээрүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх;

**Дөрөв:Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа, удирдлага зохион
байгуулалт:**



4.1. Хөтөлбөрийг 2025-2028 онд хэрэгжүүлнэ.

4.2. Хөтөлбөрийн хэрэгжилтийг Эрүүл мэндийн газар нэгдсэн эмнэлэг болон орон нутгийн эрүүл мэндийн төвүүдээ нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллана.

4.3. Хөтөлбөрийн хэрэгжилтийг хэрэгжүүлэх Эрүүл мэндийн газар нэгдсэн эмнэлэг болон орон нутгийн эрүүл мэндийн төвүүд нь бусад төрийн байгууллага, хувийн хэвшил, иргэний нийгмийн болон олон улсын байгууллага, иргэдтэй хамтран ажиллаж болно.

4.4. Сумдын Засаг дарга нар хөтөлбөрийн хэрэгжилтийг хангахад шаардагдах зардлыг орон нутгийн төсөвт тусгах, хэрэгжилтийг хангах ажлыг тухайн нутаг дэвсгэрийн хэмжээнд удирдан зохион байгуулж, үр дүнгийн тайланг сумын Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, жил бүрийн 12 дугаар сарын 01-ний дотор тайланг Эрүүл мэндийн газарт хүргүүлнэ.

4.5. Эрүүл мэндийн байгууллагуудын удирдлагууд хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагааг жил бүрийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлнэ

4.6. Хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнгийн мэдээллийг 2 жил тутамд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнана.

Тав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хөрөнгийн эх үүсвэр, санхүүжилт:

Хөтөлбөрийн санхүүжилт 4 жилд шаардагдах төсвийг дараах байдлаар хөрөнгө оруулалтуудыг татан төвлөрүүлнэ.

5.1. Улсын болон орон нутгийн төсөв

5.2. Нийгмийн хариуцлагын хүрээн дэх хувийн хэвшлийн санхүүжилт

5.3. Гадаад, дотоодын төсөл, хөтөлбөр

5.4. Хууль тогтоомжоор хориглоогүй бусад эх үүсвэр

Зургаа. Хөтөлбөрийн үр дүн

6.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр дараах үр дүнд хүрнэ;

6.1.1. Салбар хоорондын түншлэл, хамтын ажиллагаа сайжирч, орон нутгийн удирдлагын оролцоо нэмэгдэж, удирдах албан тушаалтны манлайлалын чадавхи, хүний нөөцийн мэдлэг, ур чадвар дээшилсэн байна;

6.1.2. Эмч, мэргэжилтний тасралтгүй хөгжлийн тогтолцоо бэхжиж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний шатлал бүрт тохирсон ур чадварын болон байршлын зохистой харьцаа бүрдсэн байна;

6.1.3. Нотолгоонд суурилсан шинэ технологи, аргачлалын үр дүнд оношилгоо, эмчилгээний үр дүн сайжирч, үйлчлүүлэгчийн аюулгүй байдал хангагдсан байна;

6.2.4. Эрүүл мэндийн салбарын ажиллагсдын нийгмийн баталгаа хангагдаж, ажиллах эрмэлзлэлийг нэмэгдүүлэх дэмжлэгт орчин бүрдэж, урамшууллын удирдлагын тогтолцоо төлөвшсөн байна;